



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 18/39

Аргатай

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Сангийн сайдын 2021 оны 04 сарын 20-ны өдрийн 61 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. БЗӨБЦТСтанцын Говьсүмбэр салбараас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгахад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг сум хариуцсан байцаагч (З. Ганбаяр)-д үүрэг болгосугай.

2. Албан шаардлага № 1-5 дугаарын хэрэгжилтийг хангахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэн илэрсэн зөрлийг арилгасан тухай мэдээллийг албан бичгээр хүргүүлж ажиллахыг засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Албан шаардлагыг хэрэгжүүлэн, аюулгүй ажиллах боломжийг хангахад шаардагдах 1,599,800.0 (Нэг сая таван зуун ерин есөн мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар), нягтлан бодогч (А.Цогзолмаа)-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЗОЛЗАЯА